



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 01 сарын 26 өдөр


Дугаар 4/43

Улаанбаатар хот


Гадаадын иргэн, харьяатын газрын бэлгэ тэмдэг болон түгны загвар, түүнийг хэрэглэх журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 16 дугаар зүйлийн 16.3, 16.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Гадаадын иргэн, харьяатын газрын бэлгэ тэмдгийн загвар”-ыг нэгдүгээр, “Гадаадын иргэн, харьяатын газрын түгны загвар”-ыг хоёрдугаар, “Гадаадын иргэн, харьяатын газрын бэлгэ тэмдэг, түгийг хэрэглэх журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /М.Төрбат/-т үүрэг болгосугай.



00001591



2.

Гадаадын иргэн, харьяатын гардлын
дарьйн 2017 оны дугаар
тушаалын хөрдүгүүр хавсралт



Гадаадын иргэн, харьяатын газрын
даргын 2017 оны 11 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
БЭЛГЭ ТЭМДЭГ, ТУГИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Гадаадын иргэн, харьяатын газар /цаашид “Байгууллага” гэх/-ын бэлгэ тэмдэг, тугийг үйлдэх, дүрслэх, дээдлэн хэрэглэх, хадгалахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Туг нь Байгууллагын өмч байна.

1.3. Энэхүү журмаар баталсан загвараас өөр бэлгэ тэмдэг, тугийг байгууллагын нэгжүүд хэрэглэхгүй.

Хоёр. Байгууллагын бэлгэ тэмдгийг дүрслэх, үйлдэх,
байрлуулах, хэрэглэх

2.1. Байгууллагын бэлгэ тэмдэг нь эв нэгдэл, тэш эрх, төгс төгөлдөрийг бэлгэдсэн дугуй хэлбэртэй байх бөгөөд хүний эрхийг эрхэмлэн дээдэлж, зөв чиг бодлого явуулж, үргэлж төгөлдөрших эрмэлзлэлийг илтгэнэ.

Бэлгэ тэмдгийн гадна талд дөрвөн зүг, найман зовхисыг бэлгэдсэн найман зэндмэнэ байна. Энэ нь энх амгалан, ашид дэвжихийн өлзий хутаг оршсон алтан хурдийг илтгэнэ.

Хүрдний дотор талд ариун цагаан өнгөт хүрээн дотор “ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР” гэж байгууллагын нэрийг мөнх тэнгэрийн хөх өнгийн кирилл үсгээр, “MONGOLIA IMMIGRATION AGENCY” гэж эрч хүчиний бэлгэдэл улаан өнгийн латин үсгээр тодотгон бичсэн байх бөгөөд бичвэрүүдийн дунд тариан түрүүг дүрсэлсэн байна.

Үүний дотор талд даяаршил, иргэдийн шилжилт хөдөлгөөнийг илтгэсэн цэнхэр өнгөтэй дэлхийн бөмбөрцөгийг дүрсэлсэн байна.

Дэлхийн бөмбөрцгийн дээд хэсэгт Монгол Улсын тусгаар тогтолц, бүрэн эрхт байдал, цог хийморийг илтгэсэн алтан соёмыг дүрслэнэ.

2.2. Бэлгэ тэмдгийг өнгө ялгаж буюу ялгахгүйгээр үйлдэж, дүрсэлж болно.

2.4. Бэлгэ тэмдгийн хэмжээ нь байрлуулах зүйлээс шалтгаалан өөр өөр байж болно.

2.5. Бэлгэ тэмдгийг Байгууллагын болон байгууллагын нэгжийн удирдлагын албан тасалгаа, хурал, сургалтын танхимд байрлуулна.

2.6. Бэлгэ тэмдгийг Байгууллагын хаяг, дүрэмт хувцас, тусгай хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, цахим хуудас, хэвлэл, ном сэтгүүл, танилцуулга, нэрийн хуудас зэрэгт хэрэглэнэ.

Гурав.Байгууллагын туг, түүнийг
үйлдэх, байрлуулах, хадгалах

3.1.Байгууллагын тугны дэвсгэрийг сүүн цагаан өнгөтэй цулгуй эдээр үйлдэж, тугны төвд Гадаадын иргэн, харьятын газрын бэлгэ тэмдгийг байрлуулан, бэлгэ тэмдгийн хоёр талд монгол бичгээр "ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР" гэж бичнэ. Тугны урт, өндөр нь 2:1 метр, гурван талаараа шар өнгийн цацгтай байна.

3.2.Байгууллагын тугны хэмжээ нь байрлуулах зүйлээс шалтгаалан өөр өөр байж болох бөгөөд энэ тохиолдолд эх загварт заасан тэг, харьцааг чанд баримтална.

3.3.Байгууллагын тугны эх хувийг нэг хувь үйлдэн Байгууллагын хурлын танхимд байрлуулна.

3.4.Ёслол хүндэтгэл, урлаг спортын арга хэмжээнд Байгууллагын тугийг мандуулж болно.

3.5.Байгууллагын туг гэмтсэн, хэврэгшсэн, урагдсан бол акт гарган шинээр үйлдэж, хуучин тугийг архивт хадгална.

Дөрөв.Бусад зүйл.

4.1.Байгууллагын бэлгэ тэмдгийг энэ журамд зааснаас өөрөөр дүрслэх, үйлдэх, хэрэглэх болон тугийг зөвшөөрснөөс бусад газар байрлуулах, бусдад ашиглуулахыг хориглоно.

4.2.Энэ журмын 2.4-т зааснаар Бэлгэ тэмдэг, 3.2-т зааснаар тугийг энэ журамд зааснаас өөр хэмжээгээр үйлдэх бол Тамгийн газрын даргаас зөвшөөрөл авна.